

БАГШИЙГ ТАХИХ ЁСНЫ МОНГОЛ ДАХЬ ДЭЛГЭРЭЛ БА ХӨГЖИЛ

Магистрант **Д.Биндэрьяя,**
С.Цэдэндамба (Ph.D), дэд профессор
Философи, шашин судлалын тэнхим, Хүмүүнлэгийн ухааны салбар,
Шинжлэх ухааны сургууль, МУИС

ХУРААНГҮЙ

Төвдийн бурхны шашны дөрвөн их урсалаас Монголд хамгийн их дэлгэрсэн Гэлүгва буюу шарын шашны онолын сургаал, бясалгалын заавар дотроос нэн чухал болох Энса нянжүд буюу Сонор дамжлагын нууц увдис сургаал нь бурхан багшаас тасралтгүйгээр Энэтхэгийн их багш нараар дамжиж Богд Зонховт уламжилж ирсэн байна (холын дамжлага). Мөн Богд Зонхов ойрын дамжлагаар буюу Манзуши бурхнаас сонор дамжлагын нууц увдисыг хүлээн авч, багшийн егүзрийг олон шавь нараасаа тусгайлан нууцлаж ойрын шавь болох Жамбалжамц, Хайдүвжий нарт хайлласан байна. Ийнхүү Богд Зонховын сонор дамжлагын нууц увдис нь бүтэн хоёр зууны (XV-XVII зуун) туршид олон лам нараар нууцлагдан дамжигдсаар нийтэд түгээн дэлгэрүүлсэн нь Банчэн богд Лувсанчойжижалцан бөгөөд (1570-1662) тэрбээр анх үсгэнд буулгаж “*Багшийг тахих ёс*” хэмээхийг зохиосон байна. Энэхүү нийтэд задлан түгээн дэлгэрүүлсэн Банчэн Лувсанчойжижалцан богдоос 1650 онд Монголын анхдугаар багд Жавзүндамба Хутагт ЛУВСАНДАМБИЙЖАЛЦАН буюу Өндөр гэгээн Занабазар сонорын дамжлагын гүн гүнзгий увдисыг хүлээн авсанаар Цастны орноос гурав дахь жилдээ буюу мөнхүү туулай жилийн өвлийн эхэн сард Халх нутагтаа эгэн залрав.

Ийнхүү Анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазар Банчэн багдоос уламжилж авсан “*Багшийг тахих ёс*” увдисыг бясалган бүтээж багд Зонховын судар, тарнийн шим увдис болох багшийн егүзрийг бусад хөтөлбөр зохиолдоо шинэлэгээр тайлбарлан түгээн дэлгэрүүлж байжээ. Тийнхүү Анхдугаар

Богдоос эх авч дэлгэрсэн багшийг тахих номын үзэл санаа нь хожмын Монголын номын мэргэд болох Ламын гэгээн Ханчэнчойжил Лувсандаанзанжалцан, Брагри Дамцагдож, Агваандорж, Агваанлувсандондов, Ханчэнчойжил, зая бандида Лувсанпэрэнлэй, Наймдугаар багд Агваанлувсанчойжинямаданзанванч үгбalsамбуу, Ноён хутагт зэрэг эрдэмтэн лам нар “*Багшийг тахих ёс*”-ыг бясалган бүтээж, монголчуудынхаа ёс заншил, билиг оюунд тааруулан зохиол бүтээлээ туурвиж тайлбарлан дэлгэрүүлж байсан нь зохиол бүтээлүүдээс нь харагдаж байна.

Түлхүүр үг: *Багшийн егүзэр, багшийг тахих ёс, сонор дамжлагын нууц увдис*
Үндэслэл

Төвдийн бурхны шашны дөрвөн их урсалаас Монголд хамгийн их дэлгэрсэн Гэлүгва буюу шарын шашны онолын сургаал, бясалгалын заавар дотроос нэн чухал болох Энса нянжүд буюу Сонор дамжлагын нууц увдис сургаал нь бурхан багшаас тасралтгүйгээр Энэтхэгийн их багш нараар дамжиж Богд Зонховт уламжилж иржээ.

Богд Зонховт дамжиж ирсэн багшийн егүзрийн дамжлагад холын ба ойрын гэх хоёр дамжлага байдал гэж үздэг бөгөөд холын дамжлага нь “...Чадагчийн Эрхэт Очирдариас хутагтын орны дээдэс, их шидтэн нарт дараалан дамжигдсаар Адииша гэгээн, түүнээс Дагор Ханчэн хийгээд Лховраг Дүүчэн нараас дамжсан дамжлага; мөн Наробагаас Лховраг Марбад дамжигдсан; Энэтхэгийн олон их бүтээлч нараас Богд Гой Лозавад дамжигдсан; ах дүү Пам Тимба нараас дамжигдсан; Чунбу Лхайба, цорж Дондуурэнчин, Жан-Аа Дагварэнчин, Жэзвүнрэндава тэргүүтнээс дамжсан

дамжлагыг бодг лам бүрэн гүйцэд сонссон болой”¹ гэснээс үзвэл бодг лам Энэтхэг, Төвдийн олон гарал үүсэл дамжлагын шидтэн багш нараас дамжлага хүлээж авчээ.

Бодг Зонховт дамжиж ирсэн ойрын дамжлага нь лам Умабаагаар хэлмэрчлүүлж Манзушигээс судар, тарнийн ном хязгааргүйг сонссон бөгөөд “...Манзуширид гадаад, дотоод, нууц, хоосон чанарын тахилыг өргөж, хатуу хүчтэй соёрхол талбин зохиосонд Манзуши бурхан судар, тарнийн мөрийг огоот төгсгөсөн сонорын дамжлагын² эцсийн увдисыг хайрлав”³ хэмээн бодг лам Манзуши бурхны гүн гүнзгий бясалгалд сууж нигуурыг нь болгоож Манзуши бурхнаас шууд гэгээрлийн дамжлагыг хүлээн авч дахин бурхны шашныг цөв сэлтээс нь арилгаж дахин мандан бадруулж шинэчилсэн байна.

Бодг лам Манзуши бурхантай нигуур болгоох үестээ хэрхэн хурдан ариусал тэгээрэлд хүрэх вэ хэмээн айлтгал өргөсөнд Манзуши бурхан: “Багши, ядам ялгалгүй егүзрийг мөрийн амин болгох ёс, багши нь ч аль таарсан бус хамаг мөрд хөтөлж чадах нэгэн хэрэгтэйн ёс, ядам нь

Дэмчиг /Хэрүга/, Сандуй /Гүхъясамаджса/, Жигжид /Ямандаа/ гурвуыг хослуулах хэрэгтэйн ёс, номыг тэтгэгч нь ч Гомбо Чагдуг /Саадбужа Махагала/, Дамжан Чойжал /Яма Дармаража/, Намсрай /Вайжравана/ гурвуыг шутэх хэрэгтэйн ёс”⁴ хэмээсэн байна.

Ийнхүү Бодг Зонхов Манзуши бурхнаас хүлээн авсан сонороор дамждаг нууц увдис болох багшийн егүзрийг тэнгэрийн одод эрхэс мэт олон шавь нараасаа шидтэн Жамбалжамц, Хайдүвжий нарт хайрласан байна. Тэдгээр нь Басо Чойжижалцан, түүнээс Дүвчин Чойдорж, Энса Лувсандондов, Хайдүв Санжай-еши, Лувсанчойжижалцан, Гончигжалцан, Лувсаннамжил түүнээс судалгааны эх сурвалж “Багшийг тахих их хөтөлбөр” номыг зохиогч Ёнзор Ешижалцан ламд дамжиж иржээ (Зураг 1).



Зураг 1. Бодг Зонховоос Ешижалцан ламд дамжиж ирсэн багшийн егүзрийн дамжлага

¹ Багшийг тахих их хөтөлбөр, орчуулга, х.12

² Сонор дамжлага- Багшаас шавьд уламжлах увдис сургаал.

³ Багшийг тахих их хөтөлбөр, орчуулга, х.13

⁴ Багшийг тахих их хөтөлбөр, орчуулга, х.13

Богд Зонховын сонор дамжлагын нууц увдис нь бүтэн хоёр зууны (XV-XVII зуун) туршид олон лам нараар дамжигдан нууцлагдааар Банчэн богд Лувсанчойжижалцан (1570-1662) бээр анх үсгэнд буулгаж “Багшийг тахих ёс” хэмээхийг зохиосон байна.

Ийнхүү олон зуун жилийг дамжин ирсэн Багшийг тахих их хөтөлбөр нь буддын шашны нэгэн томоохон дэлгэрлийг олсон Монгол оронд мөн түгэн дэлгэрсэн бөгөөд энэхүү уламжлал чухам хаанаас, хэн дамжуулсан тухайг судлан үзэх шаардлагатай байсан юм.

ЗОРИЛГО

Багшийг тахих ёсны дэлгэрэл Монголд хэрхэн тархсан болон уламжлан хөгжсөнийг судлан тогтоох.

ЗОРИЛТ:

1. Анхдугаар Богд Өндөр гэгээн нь Богд Зонховын сонор дамжлагын нууц увдисыг бичиг үсгэнд буулгасан Банчэн богдын зохиол болох “Багшийг тахих ёс” буюу багшийн егүзрийг хэрхэн бясалгаж Монголд анхлан дэлгэрүүлж, бүтээлээ туурвисныг судлах
2. Хойшдын Монголын эрдэмтэн лам нарын бүтээлд энэхүү зохиолын үзэл санаа хэрхэн тусаж, уламжилсан талаар судлах
3. Багшийг тахих ёсонд холбогдох бүтээлүүдийг харьцуулан шинжлэх
- 4.

I. Багшийн егүзрийг Монголд анхлан дэлгэрүүлсэн нь

Сонор дамжлагын увдисыг Монголд анх дэлгэрүүлсэн хүн нь Халхын шашны тэргүүн анхдугаар богд Жавзундамба Хутагт ЛУВСАНДАМБИЙЖАЛЦАН буюу Өндөр гэгээн (Зураг 2) бөгөөд цаг хугацааны хувьд бидний дурдан буй Ешижалцаны зохиосон “Латид чинбо” зохиолыг туурвихаас өмнө багшийн егүзрийг бясалган бүтээж Монгол орноо нийтэд түгээсэн болох нь сүмбүмээс нь мэдэгдсэн юм.



Зураг 2. Монголын Анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазар (1635-1723)

Өндөр гэгээн хэмээн алдаршсан ЗАНАБАЗАР нь Эртний Энэтхэгээс уламжлалтай Бурхны шашин, Цаст Төвдийн оройн чимэг болсон Богд Зонховын (1357-1419) Шарын шашныг хойд зүгийн талын Их Монголын онгон хөрсөн дээр суулгаж шинэчлэн боловсруулан хөгжүүлсэн, Монгол түмний оройн чимэг, шашин төрийг хослон баригч цагийг эзэлсэн Их Гэгээнтэн юм. Өндөр гэгээн Занабазар нь арван зургаан нас сүүдрийн “тийн урвагч” хэмээх цагаан төмөр барс жил буюу 1650 онд Банчэн эрдэнэ Лувсанчойжижалцан (1570-1662) богдтой залгов.

Тэр үед Банчэн богд хэдий наян хоёр нас сүүдэр хүрсэн боловч өдөр бүр бараалхаад маш их баясаж, олон зүйл авшиг хүртээсэн гэдэг. Өндөр гэгээн Банчэн богдоос гэцэл хэмээх буяны ёстны санваарыг хүртэв. Өндөр гэгээн Төвдөд удаан сууж, ном сурч судлах хүсэлтэй байгаагаа Банчэн богдод айлгасанд энэ үед алс хол Монгол оронд хуврагийн аймгийг байгуулж, шашин амьтны тусыг Үйлдвэл нэн чухал хэрэгтэй хэмээн айлдсан гэдэг. Арван долооны сүүдрийн “илжгэн” хэмээх цагаагчин төмөр туулай жил 1651 онд Далай лам Лувсанжамц (*ngag dbang blo bzang rgya mtsho*, 1617-1682) гэгээнээс “Умар зүгийн амьтны итгэл богд Жавзандамба хутагт” хэмээх цол, тамга шагнан соёрхов. Далай богд тэргүүтэн гэгээнээс гүн мөр бодь мөрийн зэргийн багшийг бясалган шүтэх хөтөлбөр, богд Зонховын ёсны Очирт эрхийн хот

мандал, дөчин таван бурхны авшиг, Очир айлгагч Ямандаг бурхны их авшиг, Гэндэнжамц Далай ламын сүмбүний эш хөтөлбөр, даган соёрхол, айлдвар зарлиг олныг сэтгэлийн хумх дүүргэхийн ёсоор хүртээд, Цастны орноос гурав дахь жилдээ буюу мөнхүү туулай жилийн өвлийн эхэн сард Халх нутагтаа эгэн залрав.

Өндөр гэгээн Далай лам, Банчэн богд нараас “Бодь мөрийн зэрэг”-ийн багшийг бясалган шүтэх хөтөлбөр зэрэг олон гүн номыг сонссонь дээр ялангуяа багшийг тахих ёсны эш хөтөлбөрт сайтар суралцаж ирсэн байна. Тийнхүү Богд Зонховоос дамжсан багшийн егүзрийг Банчэн богдоос уламжлан аваад монголчуудад очирт хөлгөний багшийг шүтэх ёсны суурь үндсийг тавьсан гэж үзэж болохоор байна.

Өндөр гэгээний Банчэн богдоос уламжлан авсан “*Багшийг тахих ёс*”-ыг судар, тарнийн шим увдис хэмээдэг. Тиймээс түүний зохиолд “*Өндөр гэгээний гүн ухааны гол бүтээл нь 85 нас сүүдэртэйдээ зохиосон “Маанийн бүтээлийн гүн арга”* хэмээх зохиол бөгөөд судар, тарнийн хамаг ишигийг хураасан арга, билгийн илэрхийлэл маанийн зургаан угсийг тарнийн тэнсэлгүй егүзрийн дээд ёсны “цагийн хүрд буюу Дүйнхэрийн үүднээс холбон тайлбарлаж, арга билиг, амгалан хоосны мөн чанарын гүн утга санааг илэрхийлсэн нь монголчуудын гүн ухааны номын үндсийг “цагийн хүрд”-ийн ёс лугаа хослон бясалгах аргыг номлосон байна.”⁵ гэснээс үзвэл Өндөр гэгээн Банчэн богдоос уламжилж авсан богд Зонховын судар, тарнийн шим увдис болох багшийн егүзрийг бусад хөтөлбөр зохиолдоо шинэлэгээр тайлбарлан түгээн дэлгэрүүлж байжээ.

Ийнхүү Банчэн богдоос хүлээн авсан “*Багшийг тахих ёс*” увдсыг бясалган бүтээж “*Маанийн бүтээлийн гүн арга*”-ыг цагийн хүрд буюу Дүйнхэрийн үүднээс холбон тайлбарлаж, арга билиг, амгалан хоосны мөн чанарын гүн утга санааг илэрхийлсэн нь монголчуудын оюун санаа, билиг оюунд тааруулан оюуны хөрсөнд өөриймшүүлэн суулгасан нь зохиол бүтээлүүдээс нь ажиглагдаж байна. Тухайлбал,

Банчэн богдын “*Багшийг тахих ёс*” зохиолд:

Багшийн лагшин, зарлиг, тааллын гурван орноос

Рашааны цагаан, улаан, хөх гурван гэрэл

Дараалан ба нэгэн зэрэг гараад миний өөрийн

Гурван оронд дараалан ба нэгэн зэрэг шингэснээр

Дөрвөн түйтгэр ариусаж, нэн ариун дөрвөн авшигийг олж

Дөрвөн лагшиг олох хийгээд багштай адилхан нэгэн

Баясан шингэснээр намайг адисалж байна⁶ гэсэн бол Өндөр гэгээний зохиосон “*Богд Зонховт шутсэн ламын нога*” /Rje btzin Tsong kha pa la brten pa’I bla ma’I rnal byor/-д:

Энэгэтийн бүхэн хурсан дээд багшийн гурван орноос

Өнгө цагаан, улаан, хөх гурван үр угсийн рашаан урсгал

Өвч зэргээр ба нэгэн хамтаар өөрт шингэснээр

Дөрвөн түйтгэр ариусаж, дөрвөн авшиг адисалыг олов

Дөрвөн лагшиг бүтээж, бүхэн хурсан багши бурхан

Оройн эсрүн нүхнээс⁷ гарч, өөрийн зурхний бадам цэцгийн дунд

Баяссаар баттай заларч, бодь хүтгийг эс олох хүртэл

Барин дагуулсаар хагацах үгүй болов хэмээн санагтуун⁸ хэмээх шүлэглэлээс харвал Өндөр гэгээн өөрийн багш болох Банчэн богдын их хөтөдбөр зохиолын утга санааг өөрийн зохиолдоо эшлэн оруулжээ.

⁵ Мягмарсүрэн Г.Өндөр гэгээний сүмбүм, УБ., 2018, х.12

⁶ Гантөмер С.Багшийг тахижүй, УБ., 2012, х.102

⁷ Сосорбурам Л.Бямбаа Р. Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл. Б.1, УБ., 2009, х.69

⁸ Сосорбурам Л.Бямбаа Р. Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл. Б.1, УБ., 2009, х.26

II. Багшийн егүзэр Монголд уламжлан дэлгэрсэн нь

Анхдугаар Богдоос эх авч дэлгэрсэн багшийг тахих номын үзэл санаа нь Ламын гэгээн Ханчэнчойжил Лувсанданзанжалцан, Брагри Дамцагдож, Ноён хутагт зэрэг Монголын эрдэмтэн лам нар “Ламын иога”⁹-г хэрхэн уламжлуулан, дэлгэрлийг олсон болох нь тэдгээрийн бүтээлүүдээс харагдаж байна. Үүнд:

1. Өндөр гэгээний ойрын шавь Ламын гэгээн Ханчэнчойжил Лувсанданзанжалцаны (1639-1703) зохиосон “Манзурид шүтсэн ламын иога” /’Jam dbyangs la brten pa’i bla ma’i rnal ‘byor/-д:

Тэр мэт сүжгийн хүчээр багши, ядам, номын сахиулсан ба

Лагишины бурхдын чуулган зэрэгчилэн

Багши ямагтад шингэх ба түүний гурван орноос

Гэрэл зэрэгчилэн ба нэгэн дор цацраад

Миний гурван оронд шингэлээ

Бас их амгалант дусал зурхэнд шингэснээр

Үйл нисваанисаас гэтэлгэж тус тус авшигийг төгсгөн

Маха мудрын их шидийг бүтээх болтугай ⁹хэмээн өгүүлсэн нь Өндөр гэгээний “Богд Зонховт шүтсэн ламын иога” зохиолтой утга ижил байгаа нь ажиглагдаж байна.

2. Ламын гэгээн Ханчэнчойжил Лувсанданзанжалцаны “Ловон бадмад шүтсэн ламын иога” /Slob dpon Padma pa’i bla ma’i rnal ‘byor/ гэх зохиолдоо:

Язгуур үндэсний багши, ядам, амирлангуй ба

Хилэнтийн байдлаар асар уужим

Багшийн хот мандлыг төгсгөхүйд

Багшийн гурван оронд УМАХУМ

Үсэгнээс гэрэл машид цацарсны

Билиг билигүүнийг урин залав¹⁰ хэмээсэн нь Ламын гэгээн гэлүгба ёсны Богд Зонховын сонорын дамжлагыг өөрийн багши Өндөр гэгээнээс уламжлан авсан ч улааны ёсны ловон Бадамжуунайд шүтсэн багшийн егүзрийг зохиосон нь очирт хөлгөний багшийн егүзрийг зөвхөн гэлүгба ёсны багши бурхдыг шүтэж бясалгах ойлголтыг өөрчилсөн байна.

3. Наймдугаар багд Агваанлувсанчойжинямаданзанвантчугбалсамбуугийн зохиосон “Бэнса сонссон дамжлагын увдисаас гарсан маш гүн ламын иога гурван давхарласан баатар сэтгэлтэн Түшидийн оронд зорчих алтан шат хэмээх оришвой” гэх зохиолд:

Багшийн лагшин зарлиг тааллын орон нугуудаас

Рашааны гэрэл цагаан улаан хөх гурав зэрэгчилэн шингэснээр

Дөрвөн түйтгэрийг сайтар арилгаж

Дөрвөн авшигийг олох бөгөөд

Дөрвөн лагшиныг хөрөнгө талбиснаар

Жич бас нэгэн зулайгаар хоёрыг таслах ёсоор

Багшийн лагшингаас тэр адилын хоёр дахь

Нэгэн мэт салах мэт залраад

Өөр ямагтад шингэснээр¹¹ гэсэн нь дээрх Өндөр гэгээний зохиол болон эх зохиол хоёртой ижлээр бичигдсэн байна.

4. Ноён хутагт Д.Данзанравжаа Брагри Дамцагдоржоос эш хөтөлбөр ном олныг сонсож байсан гэдэг бөгөөд хутагт өөрийн багшаасаа Өндөр гэгээнээс уламжилж ирсэн багшийн егүзрийг бясалган бүтээж байсан бололтой байна. Ноён хутагт Төвдийн бурхны шашны улааны ёсыг баримталдаг байсан бөгөөд гол шүтээн бурхан нь Ловон Бадамжуунай

⁹ Сосорбурам Л.Бямбаа Р.Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл. Б.1, УБ., 2009, х.1

¹⁰ Сосорбурам Л.Бямбаа Р.Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл. Б.1, УБ., 2009, х.131

¹¹ Наймдугаар багдын бууман зарлиг. МБШТ Гандантэгчилэн, УБ., 2019, х.19

бурхан бөгөөд шүтээн болсон бурхны егүзэрт оршиж бясалгадаг байжээ. Хутагт Богд лам Бадамжунийг багшид барьж, эрхэмлэдэг тухайгаа зохиол бүтээлүүддээ олонтой өгүүлсэн байдаг. “*Бурхан бүгдээс илүү ачтай*” гэдэг шүлэгтээ:

Бурхан бүгдээс илүү ачтай
Богд лам бадмасамбаа
Бодитой миний зүрхний төв дунд
Бодийг хуртэл насад цэнгэгтүн гэж
онцгойлон шүлэглэснээс үзэхэд түүний сургаалыг дагадаг бандида, хамгаас эрхэмлэдэг гол шүтээн хэн болох нь илэрхий байна.¹² гэснээс үзвэл Ноён хутагт “*Багшийг тахих ёс*”-ны увидис хөтөлбөрийг багш Брагри Дамцагдоржоос сонсож гуру Бадамжунийн багшийн егүзэрт оршдог байсан нь дээрх зохиолоос тодорхой харагдаж байна. Тиймээс Энэтхэгийн их мэргэд шидтэнүүд бүгд зохиол бүтээлүүддээ онцлон тэмдэглэсэн багшийн егүзэр нь Монголд дэлгэрсэн Төвдийн буддын дөрвөн урсгал чиглэлийн тэргүүлэх лам нар өндөр гэгээн Занабазараар уламжлан дэлгэрсэн багшийн егүзрийг бясалган бүтээж дээд эрдэм мэдлэгт хүрцгээж байжээ.

Мөн Банчэн Богд Лувсанчойжанцангаас уламжлан авсан “*Багшийг тахих ёс*” увидисанд тулгуурлаж Өндөр гэгээн болон Монголын мэргэд өөр өөрийн оюуны болон газар орны онцлогт тааруулж зохиол бүтээлүүддээ туурвиж байсан нь доорх бүтээлүүдээс нь харагдаж байна.

5. Өндөр гэгээн Лувсандамбижалцаны зохиол “*Өөр өөрийн язгуурын лам лугаа барилдуулж болох Жиргамбаагаас дамжсан увидисаар чимсэн ламын нога*” /Rang rang gi rtza ba'I bla ma la spyar chog pa'I bla ma'I rnal 'byor sKyer sgang pa las brgyud pa'I gdams pas brgyan pa/¹³ хэмээх зохиол нь өөр өөрийн багшийг бясалгагдахууны голд төлөөлүүлэн бясалгахыг үзүүлсэн байна.

6.XVIII зууны үеийн хүн болох, Их хүрээний цорж Агваандорж нь арван боть зохиол туурвисан бөгөөд түүний “*Богд Зонховыг наян шидтэнээр хүрээлүүлсэн шутсэн ламын нога сахих ёс*” /Rje btzin tzong kha pa chen po grub chen brgyad cus bskor ba la bstsen pa'i bla ma'I rnal 'byor skyong tsu/¹⁴ гэх зохиол нь монголчлон бясалгаж бүтээж дэлгэрүүлж байсан гэх үндэстэй байна. Учир нь эх зохиол болон Ешижалцан ламын “*Багшийг тахих их хөтөлбөр*” тайлбар зохиолд богд Зонховыг наян шидтэнээр хүрээлүүлсэн байдлаар бясалгах тухай утга санаа гардагүй. Үүнээс анзаараход монголчуудын задгай сэтгэлгээ юмыг хурдан сурдаг зан чанар ямар ч зүйлийг өөрийн болгож баяжуулан хөгжүүлдэг байсан оюуны их сэтгэлгээ нь ч энэхүү гэлүгба ёсны очирт хөлгөнд хамаарах багшийн егүзрийн увидисыг дэлгэрүүлж байсан зохиол бүтээлүүдэд нь тусгалаа олжээ гэж бид үзэж байна.

7.Халхын их хүрээний цорж Агваанлувсандондовын “*Наймдугаар богдын ламын нога бясалгах ёс Сүсгийн тулхүүр хэмээх оршивой*” /Rje btzin bla ma sku 'phreng brgyad ba'I rnal 'byor bsgom tsul dad pa'I lde mig ces bya ba bz:hugs so¹⁵ хэмээх зохиолд наймдугаар богдыг өөрийн багшид шүтэж багшийн егүзэрт оршуулан туурвисан байна. Банчэн богдын “*Багшийг тахих ёс*” увидис болон Ешижалцан ламын “*Багшийг тахих их хөтөлбөр*” болон бусад зохиол бүтээлүүдэд бясалгагдахууны төвд богд Зонхов юмуу Очирдарь тэргүүтнийг л бясалгах тухай гардаг бол бясалгагдахууны оронд наймдугаар богдыг бясалгах багшийн егүзрийг туурвисан нь шинэлэг бөгөөд онцлогтой харагдаж байна.

8.Брагри Ёнзон Дамцагдоржийн “*Аль биширсэн язгуурын лам лугаа найруулж болох ламын нога авч явахад амар оршивой*” /Rtza ba'i bla ma gang mos dang sbyr chog pa'i bla ma rnal 'byor 'kher bde ba bz:hugs¹⁶ хэмээх зохиол нь эх зохиолын дагуу бус, аль биширсэн багш лугаа найруулан бясалгах тухай гарч байгаа нь монголчууд өөрт дээдийн номыг заасан ямар ч багшийг бурханчлан дээдэлж шүтэж

¹² Лувсанцэрэн Г. Буддын гүн ухааны онол, түүхийн асуудлаас, төв үзэл төвшин бодлого. УБ., 2019. х.186

¹³ Сосорбурам Л. Бямбаа Р. Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл. Б.1, УБ., 2009, х.6,

¹⁴ Сосорбурам Л. Бямбаа Р. Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл. Б.2, УБ., 2009, х.644

¹⁵ Сосорбурам Л. Бямбаа Р. Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл. Б.3, УБ., 2009, х.1080

¹⁶ Сосорбурам Л. Бямбаа Р. Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл. Б.2, УБ., 2009, х.161

хүндэтгэдэг байсан нь эдгээр дээдэс мэргэд лам нарын задгай их сэтгэлгээ, оюуны загварт баригдалгүйгээр зохиол бүтээлээ турвиж байсны тод илрэл нь юм гэж үзэж болохоор байна.

9. Богд Зонховын сонор дамжлагын увидис нь хожим дэлгэрэхдээ хоёр эх сурвалжаар дэлгэрсэн гэж үздэг бөгөөд дээрхийн гэгээн XIV Далай лам Данзанжамц 2007 онд Монголчуудад айлдсан “Багшийн тахил Дэdon өрмэдма”-ийн бясалгалын хөтөлбөрийг Богд Зонховоос дамжсан сонор дамжлага болох багшийн егузэрт тайлбар хийж ялгааг нь айлдаадаа: “Богд ламын нэг гол шавь нь Жэзвүн Шаравсэнгээ бөгөөд богд лам Сара Чойдин гэдэг хэмээх газарт нууц тарнийн олон дамжлага ном болон голлон Сандуйн хүрээг айлдаад төгсгөлд нь энэ номонд эзэн болж, үүний номлолыг дэлгэрүүлэх хүрээг байгуулж чадах хэн байна вэ? хэмээн зарлигасанд бусад мэргэдүүд шууд босож зарлигийг хүлээн авч завдаагүй юм.”¹⁷ Үүнээс Сэ-жүд үүссэн хэмээгээд “Тэрхүү бодь мөрийн гол амин мод болгох ёстой багшийн егузрийн нэг нь өдгөө гэлүгбагийн шашиныг бүх дацан хийдүүдийн унишлага, Дүлнагба Балдансамбуу эвсүүлэн найруулж, унишлага хэлбэрт оруулсан гэж үздэг Ганданхавжама мөн бөгөөд энэ нь Сэ-жүдийн Богд ламтай барилдсан багшийн егузэр юм”¹⁸ хэмээсэн байна.

Мөн Далай лам цааш айлдаадаа “Харин Вэнса нянжүдийн багшийн егузэр нь лачод додэн өрмэдма” хэмээх өнөөдөр та бүгдэд хөтөлбөрийг нь хүртээж буй энэ ном мөн. Үүнийг анх Богд ламын дэргэдээс Хайдүв ринбучи болон түүний дүү Басо Чойжижсанцан нар сонссон бөгөөд Басо Чойжижсанцангаас түүний шавь их бүтээлч Дармабазар сонссон юм”¹⁹ хэмээгээд “Ер нь шинэ Гаадамба буюу богд Зонхов хөтөлбөрийн уламжлалыг харваас Гаадамба шунбава буюу гол номт Гаадамбын хөтөлбөрийн уламжлалыг үндэс болгож, түүний дээр СанДэЖиг сүмийн бясалгалыг нэмсэн

харагддаг билээ”²⁰ хэмээсэн байна. Ийнхүү Жэзвүн Шаравсэнгээс дамжсаныг Дүлнагба Балдансамбуу эвсүүлэн найруулж, унишлага хэлбэрт оруулсан гэж үздэг “Ганданхавжама” болон Энса Лувсандондооос дамжсан дамжлагыг Банчэн Чойжижалцан үсэгт буулгаж “Багшийг тахих ёс” хэмээх хоёр зохиол эх сурвалжаас монгол лам нар уламжилж багшийн егузрийг бясалган бүтээн турвиж байжээ. Тухайлбал:

- Брагри Ёнзон Дамцагдоржийн зохиосон “Ламын тахилын хөтөлбөр бичиг сонсон дамжлагын увидисын сангийн амны тэмдэг хэмээх оршивой” /Bla ma mchod ba'i khrid yig snyan rgyud man ngag gter gyi kha byang zhes bya ba bz hugs so”²¹ зохиол бол “Ганданхавжама”-д хийсэн тайлбар зохиол болно.

- Өндөр гэгээний зохиосон “Богд Зонховт шүтсэн ламын иога” /Rje btzin Tsong kha pa la brten pa'I bla ma'I rnal byor/ өөрийн багш болох Банчэн бодын увидис болох “Багшийг тахих ёс”-оос эшлэл авч зохиосон бүтээл байна.

10. Мөн зая бандида Лувсанпэрэнлэй нь зохиолд гарч буй доорх шүлэглэл нь “Багшийг тахих ёс” зохиолын тайлбар Ёнзон Ешижалцан ламын “Багшийг тахих их хөтөлбөр” зохиолд гарч буй шүлэглэлтэй ижил байна.

“Багшийг тахих их хөтөлбөр”-т:

Ямарчлан арслангийн сууг
Шавар саванд хийж бүү үйлд
Түүнчлэн их егуэрийн дамжлагыг
Сав бусад бүү өгч үйлд
Саахь шавь тэр л агшинд үхнэ
Сац энэ хийгээд чинадад доройтно²².

гэсэнтэй зая бандида Лувсанпэрэнлэйн Тусгаар зарлигийн авшиг олныг олсон ёсыг номлосны их бүлэг сарга зохиол дахь “Авшиг авах” хэсэгт “Очир эрих”-ээс

Ямар мэт арслангийн сууг нь
Шороон саванд агуулан үл үйлдэх
Түүнчлэн иогын их үндсийг

¹⁷ Гантөмөр С. Багшийг тахихуй, УБ., 2012. х.10

¹⁸ Гантөмөр С. Багшийг тахихуй, УБ., 2012. х.15

¹⁹ Гантөмөр С. Багшийг тахихуй, УБ., 2012. х.15

²⁰ Гантөмөр С. Багшийг тахихуй, УБ., 2012. х.10

²¹ Сосорбурям Л. Р.Бямбаа Р. Монголчуудын төвд хэлээр турвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл. Б.2, УБ., 2009, х.295

²² Батцэнгэл А. Багшийг тахих их хөтөлбөр. УБ., 2013, х.38

*Сав бусуудад өгөн ул үйлдмүй.
Шавь нэгэн агшин түүнээ үхмүй
Энэ хийгээд хойтод нь доройтмуй
Сав буст дор увдисыг сайтар
номловоос*

Сургаалын багшийн шид буурахуяа болмуй²³ хэмээх шүлэглэл нь ижил харагдаж байна. Энэ нь Ёнзон Ешижалцан ламын “Багшийг тахих их хөтөлбөр” зохиолыг Монголын эрдэмтэн лам нар судлан суралцаж бясалган бүтээж зохиол тайлбартаа эшилж байсан нь дээрх зохиолоос тодорхой байна.

11. Монголын сүүлийн үеийн эрдэмтэд судалгаандаа Монголын хаадууд тэр дундаа Хубилай хаан багшийн егүзрийг бясалган бүтээж байсан талаар бичсэн байна. Г.Лувсанцэрэн багш “Академич Ш.Бира (2007) Хубилайн хос ёсны бодлого, уйл ажиллагаа, түүнчлэн түүний онолын үндэслэлийг боловсруулан номлосон Пагва лам Лодойжалцангийн уйл, бүтээлийн тухайд академич олон жилийн өмнөөс нягталж ирсэн судалгаа сүүлийн үеийн бүтээлдээ үргэлжлүүлэн дүгнэжээ²⁴ гээд тэрээр цааш “Хубилай хаан нууц тарниийн авшигийг Пагва ламаас хэд хэдэн удаа хүртсэн нь Нууц тарниийн номын ёсоор Махгала Ядам бурхны билиг ухааны цогцыг өөртөө дамжуулан авч, улмаар Их эзэн хаан, Ядам бурхан хоёрын дээдийн ариун мөн чанар нь харилцан нийлж, нэгэн цогцос болон хувирч, Монголын их эзэн хааны бурханлиг дурийг бүтээхэд уг авшигийн гол учир утга оршиж байжээ” гэж тус үйл явцын дотоод нарийн учрыг илэрхийлсэн байна²⁵

ДҮГНЭЛТ

1. Бурхан багшаас сонор дамжлагын увдис нь хутагтын орны дээдэс, их шидтэн нарт дараалан тасралтгүй дамжигдсаар Адиша гэгээн, Дагор Ханчэн, Лховраг Дүвчэн, Богд Зонхов Нароба, лховраг Марба, Богд Гой Лозава, Пам Тимба Чүнбу Лхайба, цорж Дондуурэнчин, Жан-Аа Дагварэнчин, Жэзвүнрэндава тэргүүтнээс Богд Зонхов бээр бүрэн гүйцэд сонссон гэж “Багшийг тахих их хөтөлбөр” тайлбар зохиолд тусгасан байдаг. Гэсэн хэдий ч Богд Зонхов Манзушири бурханд гадаад, дотоод, нууц, хоосон чанарын тахил хязгааргүй өргөн тахиж, гүн гүнзгий бясалгалд сууж нигуурыг нь болгоосноор бурхан багшаас Манзуширид дамжсан авшигийг шууд хүлээж авч Төвд оронд доройтоод байсан бурхны шашныг дахин шинийн саран мэт шинэчлэн мандуулан дэлгэрүүлсэн байна. Улмаар богд Зонховын Манзушири бурханаас сонссон “сонор дамжлага”-ын увдисыг анхдугаар богд Өндөр гэгээн Занабазараар дамжигдаж Монгол оронд дэлгэрсэн гэх үндэстэй байна.
2. Богд Зонховоос дамжсан багшийн егүзрийн увдис дамжлагыг Банчэн Лувсанчойжижанцан боддоос анхдугаар богд өндөр гэгээн Занабазар нь хүлээн авч анхлан Монгол оронд дэлгэрүүлсэн бөгөөд хожим нь Монголын мэргэд бясалган бүтээж, монголчуудынхаа ёс заншил, билиг оюунд тааруулан зохиол бүтээлээ туурвиж тайлбарлан дэлгэрүүлж байжээ. Үүний жишээ нь Өндөр гэгээн Лувсандамбыжалцан, Агваандорж, Агваанлуvsандондов, Брагри Ёнзон Дамцагдорж зэрэг мэргэд дээдсийн бүтээлүүд болно. Өндөр гэгээн болон наймдугаар богд тэргүүтний зохиосон багшийн егүзэр нь эх сурвалж болох “Багшийг тахих ёс” зохиолд суурилж зохиогдсон бололтой байна.
3. Богд Зонховын сонор дамжлагын увдис нь хожим дэлгэрэхдээ хоёр эх сурвалжаар дэлгэрсэн гэж үздэг бөгөөд Богд ламаас Жэзвүн Шаравсэнгээс

²³ Ням-Очир П. Гэгээн толь, УБ., 2019, х.377

²⁴ Лувсанцэрэн Г. Нагаржунагийн философиийн үзэл, төв үзлийн философиийн онолын үндэс, I боть, УБ.,2019, х.265

²⁵ Лувсанцэрэн Г. Нагаржунагийн философиийн үзэл, төв үзлийн философиийн онолын үндэс, I боть, УБ.,2019, х.265

дамжсаныг Дүлнагба Балдансамбуу эвсүүлэн найруулж, уншлага хэлбэрт оруулсан “Гандаанхавжама” болон Энса Лувсандондооос дамжсан дамжлагыг Банчэн Чойжижалцан үсэгт буулгасан “Багшийг тахих ёс” хэмээх хоёр эх сурвалж зохиолоос монгол лам нар уламжилж багшийн егүзрийг бясалган туурвиж байжээ. Үүнээс Монголын мэргэд өөр өөрийн сүсэгт тааруулж өөрийн багш лугаа найруулан багшийн егүзрийг бясалган бүтээж түгээн дэлгэрүүлж байжээ гэх үндэстэй байна. “Төвд хүн сахил санваараа эрдэмтэй болдог, Монгол хүн багшийг шүтэх ёсоороо эрдэмтэй болдог” гэх хэлц үг Төвдөд гарсан бөгөөд дээрх монгол лам нарын багшийгаа бурхан мэт шүтэх багшийн егүзрийн зохиолууд лугаа нийцэж байна. Монголд багшийн егүзэр буюу багшийгаа бурханчлан дээдлэх шүтлэг машид хүчтэй дэлгэрсэн нь энэхүү багшийн егүзрийг сайтар мэддэг байсантай холбогдоно.

4. Ламын гэгээн гэлүгба ёсны Богд Зонховын сонорын дамжлагыг өөрийн багш Өндөр гэгээнээс уламжлан авсан ч улааны ёсны ловон Бадамжуунайд шүтсэн багшийн егүзрийг зохиосон нь очирт хөлгөний багшийн егүзрийг зөвхөн гэлүгба ёсны багш бурхдыг шүтэж бясалгах ойлголтыг өөрчилсөн байна. Мөн монгол лам нар Богд Зонхов болон Очирдайг бясалгагдахууны төв болголгүйгээр өөрийн багшийг гол бясалгагдахуун болгон бясалгаж байснаараа онцлогтой. Бурхны шашны Төвдөд дэлгэрсэн дервөн урсгалыг ялгаж үзэлгүй багш бурхад нэгдмэл гэх санааг дэвшүүлснээрээ илүү дэвшилтэт нийтлэг байж багшийг шүтэх ёс багш бурхад үнэмлэхүйдээ нэгдмэл ба өөрийн сэтгэлд нэгдмэл гэх санааг илүү тодруулсан байгаа нь төвдүүдийн багшийн егүзрээс онцлогтой олон ургалч очирт хөлгөний оюунаас халин гарсан торолтгүй билгүүний ухааныг гаргаж ирснээрээ монголчуудын задгай сэтгэлгээг багшийг шүтэх ёсонд тод томрууун оруулан монголчуудын оюун ухаанд буулгаж хөгжүүлсэн нь тодорхой байна гэж үзэж болохоор байна.

Ном зүй

1. Bla ma mchod pa'i khrid yig gsang ba'i gnad gnam par phye ba snyan rgyud man ngag gi gter mdzod ces bya ba bzhugs so, “Багшийг тахихуйн хөтөлбөр” Нууц аньсыг машид нээгч сонорын дамжлага увидын гуу сан. Sera mey library. India., 2007
2. Багшийг тахихуйн их хөтөлбөр (Жода ринбүчийн тайлбар). Батцэнгэл А. орчуулга. УБ., 2013
3. Багшийг тахихуй, “Багшийн тахил Дэдон ермэдма”-гийн бясалгалын хөтөлбөр. (XIV Далай ламын тайлбар), Гантөмөр С. орчуулга. УБ., 2012
4. Багшийг тахихуй, Гантөмөр С. орчуулга. УБ., 2012
5. Бодь мөрийн зэрэг, Пүрэвbat Г. орчуулга. УБ., 2003
6. Бодь мөрийн зэргийн бясалгахуйн их хөтөлбөр. Гантөмөр С. орчуулга. УБ., 2013
7. Бодь мөрийн зэрэг гэтлэхүйн гарын авлага (Павнха Ринбүчийн зохиол), Санкарбат Ц. орчуулга. УБ., 2011
8. Дияан, Болдбаатар Д. орчуулга. УБ., 2011
9. Их бодь мөрийн зэрэг. Булган Т. орчуулга. УБ., 2004
10. Лувсанцэрэн Г. Буддын гүн ухааны онол, түүхийн асуудлаас, төв үзэл төвшин бодлого. УБ., 2019.
11. Лувсанцэрэн Г. Нагаржунагийн философиин үзэл, төв үзлийн философиийн онолын үндэс, I боть, УБ., 2019
12. Г. Лхагвасүрэн, Ноён хутагт Данзанравжаа (гүн ухааны үзэл) эрдмийн бүтээл 1, УБ., 2018
13. Монгол хэлний их тайлбар толь mongoltoli.mn
14. Мягмарсүрэн Г. Өндөр гэгээний сүмбүм, УБ., 2018
15. Наймдугаар богдын буман зарлиг. МБШТ Гандантэгчилэн, УБ., 2019
16. Гэгээн толь, Ням-Очир П. орчуулга. УБ., 2019
17. Пүрэвжав Э. Бат-Эрдэнэ С. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь II (Д-Л). УБ., 2008
18. Улааны шашны Зогчэн сургаал.

- Пүрэвсүх У. орчуулга. УБ., 2012.
19. Сосорбурам Л. Бямбаа Р. Монголчуудын Төвөд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл. Б.1, УБ., 2009
20. Сосорбурам Л. Бямбаа Р. Монголчуудын Төвөд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл. Б.2, УБ., 2009
21. Сосорбурам Л. Бямбаа Р. Монголчуудын Төвөд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл. Б.3, УБ., 2009
22. Сургаалын ном, будда, meal. Video. blog
23. Чоймаа III., Крилл, монгол тайлбар толь, УБ., 2011
24. Чоймаа III., Л.Тэрбиш, Д.Бүрнээ, Л.Чулуунбаатар. Буддын шашин соёлын тайлбар толь. Буддын судлал Цуврал II. УБ., 1999
25. Чимэг О. Зонхавын “Бодь мөрийн зэрэг” дэх нийгмийн философиийн үзэл санаа. Философиийн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2001

ABSTRACT

Ensa Nyanjud or the secret charm of sonor transmission, which is the most important among the teachings and meditation instructions of Gelugpa Yellow Hat, has been continuously transmitted from Buddha to Bogd Zonkhova or Tsongkhapa through the great gurus of India (long-distance transmission). Gelugpa Yellow Hat is the most popular one among the four great sects of Tibetan Buddhism in Mongolia. Bogd Zonkhov also received the secret charm of sonor transmission from bodhisattva Manjushri or through his close transmission and transmitted the meditation for gurus to his close disciples Jambalzhamts and Haiduvjii upon keeping it confidential from many of his other disciples. Thus, the secret charm of Bogd Zonkhova’s sonor transmission was passed on to the public by many monks

during two centuries (XV-XVII centuries) and Banchen Bogd Luvsanchoijijaltsan (1570-1662) was the first monk who put it in the written form and authorized the *sutra* “*Guru reverence custom*”.

In 1650, the first Javzundamba Hutagt LUVSANDAMBIJJALTSAN or High Saint Zanabazar received the asceticism skills of Sonor transmission from Banchen Luvsanchoijizhaltsan Bogd who spread it to the public. Then High Saint Zanabazar returned back to Mongolia from Tibet on the third year or in the first month of winter of the Year of Rabbit. In this way, the First Bogd High Saint Zanabazar created the Guru Reverence asceticism, learned from Banchen Bogd, and widely spread the Bogd Zonkhov sutra and tantra skills or the Guru asceticism by including them in his other sutras and programs.

Thus, the idea of guru reverence, spread by the First Bogd, was developed among Mongolian scholars and monks such as Lamyn Gegeen Khanchenchoijil Luvsandanjanjaltsan, Bragri Damtsagdoj, Agwaandorj, Agwaanluvsandondov, Khanchenchoijil, Zaya Bandida LuvsanperenleI, Eighth Bogd Agwaanluvsanchoijinyamadanzanvanchugbalsambuu, and Noyon Hutagt. It is observed from their works and sutras authored by these scholars and monks that they created the *Guru reverence custom* with their asceticism and divulged their works in accordance with the custom and wisdom of the Mongolian people.